

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭН ДҮГНЭЛТ

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Засвар тохижилтын ажилд:

№	Хийгдсэн ажлууд	Гүйцэтгэл
1.	Хэрлэн худалдаа, үйлчилгээний төвийн ариун цэвэр, ариутгалыг сайжруулах, чангатгах	Гүйцэтгэсэн
2.	Супермаркетын хөргөлтийн системийг шинээр солих	Гүйцэтгэсэн
3.	“Анхилуун” зоогийн газрын Б заалыг орчин үеийн интерьер дизайнээр засаж тохижуулан их засвар хийж нийтийн Караоке болгох	Гүйцэтгээгүй
4.	Худалдааны Төвийн 1-р давхрын нүүрэн талын шилэн фасад хийх	Гүйцэтгээгүй
5.	Худалдааны төвийн 1-р давхрын Аж ахуйн нэгжүүдийн байршил, интерьер дизайныг өөрчлөн засвар тохижилт их засвар хийж, хана, хаалгануудыг гэрэл нэвтрэх шилэн болгох, байгалийн чулуугаар ханыг өнгөлөх	Дутуу
6.	1-р давхрын Гэрэл, камерын монтажийг иж бүрэн сольж шинэчлэх	Гүйцэтгэсэн
7.	Компанийн цахилгааны монтаж бүрэн шинэчлэх	Дутуу
8.	Худалдааны төвийн үүдний хоёр талын фасад, шатанд их засвар хийж, фасадын өнгөлгөөг шинэчлэн байгалийн чулуугаар солих, шатны гишгүүрийн эвдэрсэн хэсэгт цутгалт хийх	Дутуу
9.	Жавхлантын 2 давхрыг ресторан болгож иж бүрэн засвар хийх	Гүйцэтгээгүй
10.	Төвийн орох 3 урсгалт гол хаалгыг бүрэн шиллэн, байгалийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, интерьер тохижилтыг сайжруулах	Дутуу
11.	Худалдааны Төвийн объектыг 280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шилэн фасад болгон засвар тохижилтын ажил хийж, дулааны алдагдлыг багасгах	Гүйцэтгээгүй
12.	Барааны Жавхланта хэсгийн дээврийн хучилтад их засвар хийх	Гүйцэтгээгүй
13.	Жавхланта хэсгийн ашиглагдаагүй байгаа зааланд их засвар хийж, заалыг ашиглалтад оруулах	Гүйцэтгэсэн (Гүйцэтгэл 45%)
14.	Барааны орох хэсгийн шат, чулуун хана, шатны гишгүүр, бариул зэргийг шинэчлэн сайжруулах	Гүйцэтгэсэн
15.	Хүнсний захын орох хаалганы фасад, бэлтгэлийн өрөөний хаалга, ногооны агуулахад их засварын ажил хийх	Гүйцэтгэсэн
16.	Худалдааны Төвийн орох, гарах хэсэг болон гаднах орчны тохижилт, цэцэрлэгжүүлэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу 2020 онд <ul style="list-style-type: none"> • “Анхилуун” зоогийн газрын орох хэсгийн шилэн павильоны дээвэр, шал, хананы засварыг дуусгах 	Гүйцэтгэсэн

	<ul style="list-style-type: none"> Худалдааны Төвийн орох хэсгийн шат, фасад, ногоон байгууламжийн хашлага, хайсан засаж тохижуулах 	
17.	Рестораны тавилга ширээ, сандал, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх	Гүйцэтгээгүй
18.	Бөөний агуулахад агуулахын объектод их засвар хийж бөөний төв болгох	Гүйцэтгээгүй

Хоёр. Үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хийсэн ажилд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	Үйл ажиллагаагаа өргөжүүлэн, Булган аймгийн Могод суманд халуун рашаан сувилал байгуулах төсөл хэрэгжүүлэх	Гүйцэтгээгүй
2.	Борлуулалтыг өргөтгөх, хэрэглэгчдийг хүнсний өргөн хэрэглээний чанартай бүтээгдэхүүнээр хангах ажлыг гүйцэтгэх	Гүйцэтгэсэн
3.	Хэрлэн супермаркетын бараа борлуулалтыг нэмэгдүүлэн байгууллагуудтай гэрээ байгуулан бараа материалыг захиалгаар ханган нийлүүлнэ.	Гүйцэтгэсэн
4.	Тэмдэглэлт ой баяруудаар цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүний өргөтгөсөн болон урамшуулалт худалдаа, бэлгийн багц бэлтгэх, захиалгат, хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулах	Гүйцэтгэсэн
5.	Дэлгүүрийн хөргөгч, хөргүүрийн тоог нэмэгдүүлэн барааны хадгалалт хамгаалалтыг сайжруулан, заалны ашиглалтыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэсэн
6.	Орон нутгийн телевиз, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан зар сурталчилгаа тогтмол явуулж үйл ажиллагаагаа сурталчилна.	Гүйцэтгээгүй
7.	Харуул хамгаалалтаа сайжруулан хяналтын камер, дохиоллын тоог нэмэгдүүлнэ.	Гүйцэтгээгүй
8.	Анхилуун Зоогийн газрын хоол үйлдвэрлэлийг сайжруулан, Хүлээн авалт, Хурим, Найр, Хүндэтгэл зоогийн арга хэмжээг зохион байгуулах	Гүйцэтгээгүй
9.	Ашиглагдаагүй заал талбайн ашиглалтыг сайжруулан, заалны дүүргэлтийг нэмэгдүүлэх, томоохон үйлдвэрийн худалдааны салбарыг нээх	Гүйцэтгээгүй

Гурав. Ажилчдын нийгмийн бодлого, боловсролд чиглэсэн ажлууд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	Ажилчдын эрүүл мэндэд анхаарч тэжээллэг хоол унд олгох	Гүйцэтгэсэн (Гүйцэтгэл 80%)
2.	Эмчилгээ сувилгаанд хамруулан зардал хөнгөлөлт үзүүлэх	Гүйцэтгэсэн (Гүйцэтгэл 90%)
3.	Эрүүлжүүлэх бясалгалын хичээлд хамруулах	Гүйцэтгэсэн

4.	Эрүүл мэндийн дасгал сургууль зохион байгуулах	Гүйцэтгэсэн
5.	Албан хаагчдын хүүхэд залуучуудыг гэрээгээр суралцуулан, сургалтын төлбөрт хөнгөлөлт, хандив үзүүлэх, дадлагажуулах, ажлын байраар хангах	Гүйцэтгээгүй
6.	Шаардлагатай ажил мэргэжлийн сургалтад хамруулах	Гүйцэтгээгүй
7.	Гэр хороололд амьдардаг ажилтан, албан хаагчдад нүүрс түлээний хөнгөлөлт олгох.	Гүйцэтгэсэн
8.	Ажилчдад тохиолдсон баяр баясгалан, зовлон бэрхшээлийг хуваалцаж санхүү, эд материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх	Гүйцэтгээгүй

Дөрөв. Дүүрэг болон нийгэм, иргэдэд чиглэсэн ажилд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин зохиогдож буй арга хэмжээг, сургалт сурталчилгааг ойртуулан өөрийн компанийн байранд зохион байгуулж ажилтан албан хаагчид, түрээслэгчдийг хамруулна.	Гүйцэтгээгүй
2.	Харьяалалтай өндөр настан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, тохиолдсон уй гашуу, баяр баясгаланг хамт хуваалцана.	Гүйцэтгээгүй
3.	Харьяа хорооны зорилтот бүлгийн хүүхдүүдэд хандив туслалцаа үзүүлэх. Идэвх, санаачилга гарган ажиллах. 2 хүүхдэд 18 нас хүртэл хадгаламж нээнэ.	Гүйцэтгээгүй
4.	Төрийн ба төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй хүмүүнлэгийн ажилд идэвхтэй оролцоно	Гүйцэтгээгүй
5.	Нийгмийн эрүүл мэндэд анхаарч “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” нийтийн цэнгээнт бүжгийг өөрийн компанийн байранд тогтмол зохион явуулна	Гүйцэтгээгүй
6.	Дүүргийн иргэд, хөдөлмөрчдөд үзүүлэх байнгын ажлын байрны тоог нэмэгдүүлнэ	Гүйцэтгээгүй